



ДОРНОГОВЬ АЙМАГ
АЙРАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/57

Цагаандөрвөлж

Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага
худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.17 дахь заалт, 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн “Улсын хэмжээнд 2026 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил хэмжээ, зориулалтын жагсаалт” 45 дугаар тогтоол, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/188 дугаар “Аргачлал шинэчлэн батлах тухай” тушаал, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн “Газар зохион байгуулалтын 2026 оны төлөвлөгөө батлах тухай” 07/35 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын газар зохион байгуулалтын 2026 оны төлөвлөгөөний дагуу хавсралтад дурьдагдсан газруудад эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдааг зохион байгуулсугай.

2.Газар эзэмшүүлэх дуудлага худалдааг зохих журмын дагуу 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулахыг Газрын даамал (Т.Золбоо)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Туул)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.ГАНБААТАР



Айраг сумын Засаг даргын *д.О.О.* оны
04. дүгээр сарын *02.* өдрийн *157* дугаар
захирамжийн хавсралт



**ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЖУРМААР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ГАЗРЫН БАЙРШИЛ,
ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ, ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ЗАРЛАХ ҮНЭ**

Д/д	Баг	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Газрын байршил	Газрын хэмжээ (м2)	Газрын зориулалт	Дуудлага худалдааны анхны үнэ (төгрөг)	Дэнчингийн хэмжээ (төгрөг)
1	1-р баг	4895592	Нэргүй толгой	2746	Цахилгаан, эрчим хүч дамжуулах шугам	54,820	5,482
2	1-р баг	4915549	Дорноговийн-Үйлс ХХК	166917	Цахилгаан, эрчим хүч дамжуулах шугам	3,338,340	333,834
3	1-р баг	4915550	Дорноговийн-Үйлс ХХК	6212	Цахилгаан, эрчим хүч дамжуулах шугам	124,240	12,424
Нийт				175875		3,517,400	351,740

о-О-о